



ЖАВХЛАНТ СУМЫН АРДЧИЛСАН  
НАМЫН ХОРООНД

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2020-07-30 № 07-2020/04-НА-25  
танай -ны № -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жавхлант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Жавхлант сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Жавхлант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Жавхлант сумын Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020615


## Дүгнэлт

Жавхлант сумын Ардчилсан намын хорооны Жавхлант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцооор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Жавхлант сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр / 10. хуудас /-ийг хавсаргав.

Хувийг: Жавхлант сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ЧЭНХТУЯА



# **СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЖАВХЛАНТ СУМЫН 2020 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ЖАВХЛАНТ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

## **УРИА: ӨРХИЙН ӨСӨЛТӨӨС ЖАВХЛАНТЫН ХӨГЖИЛ**

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, нутгийн удирдлага, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд сууринсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд:

Иргэн бүрийг хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, ардчилсан Жавхлант сумаа хөгжүүлэхийг **ЭРХЭМ ЗОРИЛГО** болгож,

- Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах хувь хүний эрх чөлөө,
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал,
- Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЖАВХЛАНТ СУМЫН АРДЧИЛСАН НАМ 2020-2024 оны орон нутгийн ИТХ-ын сонгуульд “ӨРХИЙГ ДЭМЖСЭН – ӨСӨЛТИЙН БОДЛОГО” мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.

## **НЭГ. ХУВЬ ХҮН, НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ**

### **1.1 Өрсөлдөх чадвартай боловсрол**

- 1.1.1 Хүүхэд бүрийг хөгжүүлж, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.1.2 Гадаадын их, дээд сургуульд шилдэг сурагчдыг оюутны тэтгэлгээр суралцах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.
- 1.1.3 Хүүхэд залуучуудыг хөгжүүлэх “JAVHLANT STEAM” хөтөлбөрийг сумандаа хэрэгжүүлнэ. /Шинжлэх ухаан, технологи, инженер, урлаг, математик хөгжил/
- 1.1.4 Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй/ хүүхэд, иргэдийг дохионы хэлний сургалтад хамруулахад бодлогоор дэмжиж, нийгмийн баталгааг хангана.
- 1.1.5 Багш нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, давтан сургаж, “Шинэ Багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.1.6 Сумын ЗДТГ, өрөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын багш, эрүүл мэндийн байгууллагын өмч, эмнэлгийн ажилтан нарын мэргэжил мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор гадаадын түнш орнуудтай хамтарч ажиллана.
- 1.1.7 ХАА-н чиглэлийн их, дээд сургууль, МСҮТ, коллежид суралцаж буй хүүхэд, залуучуудыг сумандаа ажиллах нөхцөл боломжоор хангана.

- 1.1.8 Сумын эрэлтэд суурилсан инженер, техникч, технологич, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, маркетингийн мэргэжилтнийг бэлтгэхэд бодлогоор дэмжинэ.
- 1.1.9 Иргэний боловсролыг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.
- 1.1.10 Иргэдийн цахим боловсролыг дээшлүүлнэ.
- 1.1.11 Ерөнхий боловсролын сургуулийн химиин болон байгалийн ухааны кабинетуудыг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангана.
- 1.1.12 Сургуулийн гадна биеийн тамирын талбайг тохижуулж техник хэрэгслээр хангана.
- 1.1.13 Сургуулийн ширээ сандлыг шинэчилж, анги танхимиын тохижилтыг сайжруулна.
- 1.1.14 Цэцэрлэгийн багш хөгжлийн төв, дуу хөгжмийн кабинет, багш, албан хаагчдын компьютер, тавилга, тоног төхөөрөмжийг шинэчлэх санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулан хэрэгжүүлнэ.
- 1.1.15 Цэцэрлэгийн барилгын их засварын санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулан хэрэгжүүлнэ.

## 1.2 Эрүүл мэндийн үйлчилгээ

- 1.2.1 Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.
- 1.2.2 Сумын эрүүл мэндийн төвийн тусlamж үйлчилгээг түргэн шуурхай, чанар хүртээмжтэй, ил тод, ёс зүйтэй, иргэддээ ээлтэй болгоно.
- 1.2.3 Хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулах, эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллана.
- 1.2.4 Иргэдийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулна.
- 1.2.5 Түргэн тусlamжийн үйлчилгээний зохион байгуулалтыг шинэчилж, материаллаг баазыг бэхжүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг дээшлүүлнэ.
- 1.2.6 Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч, сувилагч нарыг эрүүл мэндийн төвд зөвлөхөөр ажиллуулах боломжийг бүрдүүлж, бодлогоор дэмжинэ.
- 1.2.7 Уламжлалт анагаах ухааны өв санд суурилж, уламжлалт эмчилгээ, үйлчилгээний брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.2.8 Эрүүл мэндийн даатгалын цахим картыг нэвтрүүлж, хөнгөлөлттэй эмийн жороор үйлчилэх үйл ажиллагааг дэмжинэ.
- 1.2.9 Эмийн хэрэглээ, хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулахад холбогдох байгууллагатай хамтран ажиллана.
- 1.2.10 Эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөл бололцоогоор хангаж ажиллана.
- 1.2.11 Түргэн тусlamж, ариутгал халдвартгүйтгэл, сэргээн засах эмчилгээ, үйлчилгээний тоног төхөөрөмжүүдийг нэмэгдүүлэх санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулан, хэрэгжүүлнэ.

- 1.2.12 Түргэн тусламжийн автомашины тоноглол, моргийн өргөтгөл, хөргүүр, эмнэлгийн гаралтай хог хаягдлын стандартын цэг байгуулах санхүүжилтийг холбогдох шатны төсөвт тусгуулж, хэрэгжүүлнэ.
- 1.2.13 Тогтвортой ажиллах гэрээний дагуу эмч, эмнэлгийн ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх, суралцах хугацааны нийгмийн хангамжийг бүрдүүлнэ.
- 1.2.14 Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, худаг, дээврийн засварын ажлыг бүрэн хийж дуусгана.

### **1.3 Хүн амын өсөлт, хөгжил**

- 1.3.1 Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн насын хүүхдийг хүмүүжүүлэх бодлого, хүүхдийг гэр бүлийнхээ орчинд, ээж аавтайгаа хамт хүмүүжиж төлөвших хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого баримтална.
- 1.3.2 Гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.3.3 Гэр бүлийн өрхийн бизнес, санхүүг дэмжсэн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 1.3.4 Хүүхэд харах үйлчилгээг нэвтрүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.3.5 Гэр хорооллын дахин төлөвлөлтийг ипотекийн зээлтэй уялдуулан үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1.3.6 Зээлийн хөнгөлөлттэй нөхцөлөөр хувийн орон сууцтай болгох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.3.7 Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангана.
- 1.3.8 Гэр бүлийн бат бэх байдлыг дэмжиж гэр бүл – нөхөн үржихүйн боловсролыг дээшлүүлж, өрх толгойлсон эх /ганц бие эцэг/, хүүхдийг эрсдэлээс хамгаалах нөхцөлийг сайжруулна.
- 1.3.9 Жендерт суурилсан хүчирхийлэл, ялгavarлан гадуурхал, бэлгийн дарамтыг арилгах санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- 1.3.10 Өсвөр үе, залуучууд, оюутны спорт, урлагийн наадмыг зохион байгуулах залуучуудын санал санаачилгыг дэмжинэ.

### **1.4 Ажлын байр, хөдөлмөр эрхлэлт**

- 1.4.1 Сумын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.
- 1.4.2 Хэрэгцээтэй байгаа ажил мэргэжлийг нарийвчлан гаргаж, их дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагатай хамтран ажиллана.
- 1.4.3 Хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэр (цагийн ажил, аутсорсинг, сүлжээний борлуулалт, ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ г.м.)-ийг хүлээн зөвшөөрнө.

- 1.4.4 Орон нутагт гарааны бизнес буюу старт-апыг хөгжүүлэх экосистем (санхүүжилт, сургалт, мэдээлэл, г.м.)-ийг бүрдүүлнэ.
- 1.4.5 Гарааны бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.
- 1.4.6 Сумын аялал жуулчлал, үйлчилгээний салбарт ажлын байрыг шинээр бий болгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамtran ажиллана.
- 1.4.7 2018-2030 он хүртэл “Дэлхийн Зөн Монгол” ОУ-ын байгууллагын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамtran ажиллана.
- 1.4.8 Зөгий, тахиа, шувууны аж ахуй эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.

### **1.5 Нийгмийн хамгаалал**

- 1.5.1 Нийгмийн халамжийг шаардлагатай өрх, иргэд рүү төвлөрүүлж, зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой бодлого хэрэгжүүлнэ.
- 1.5.2 Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, сайн дурын даатгуулагчдын тоог нэмэгдүүлнэ.
- 1.5.3 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж, асрамжийн үйлчилгээг төрөлжүүлж ажиллуулна.
- 1.5.4 Сумын ахмадуудыг рашаан, сувиллуудад болон уламжлалт анагаах ухаанаар эмчлүүлэх нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.5.5 Нийгмийн халамжийн салбарт сайн дурын ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.5.6 Иргэд, малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.
- 1.5.7 Сумын Ахмадын хорооны санал санаачилгыг дэмжиж ажиллана.

### **1.6 Соёл , урлаг , спорт**

- 1.6.1 Уламжлалт өв соёлоо бодлогоор дэмжин соёлын өвийг тоон системд хөрвүүлэн хадгалж, олны хүртээл болгох ажлыг эхлүүлнэ.
- 1.6.2 Сумынхаа соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжинэ.
- 1.6.3 Археологийн болон түүх соёлын дурсгалт газрын бүртгэл, хамгаалалтыг сайжруулна.
- 1.6.4 Мэргэжлийн урлагийн байгууллага, залуу уран бүтээлчдийн уран бүтээлээ олны хүртээл болгох, ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.6.5 Сайн дурын уран сайханчид болон урлагийн холбоодын үүсгэл санаачилгыг дэмжинэ.
- 1.6.6 Үндэсний өв соёл, зан заншлыг сэргээн хөгжүүлэх, сурталчилж өвлүүлэх зорилгоор сумын үндэстэн, ястны язгуур урлагийн наадмыг зохион байгуулж ардын авьяастнуудыг тодруулна.
- 1.6.7 Монгол зан үлийн танхимыг өргөө болгон тохижуулж, үндэсний тоглоом наадгайг хөгжүүлнэ.
- 1.6.8 Түүх, соёлын агуулга бүхий контентыг хөгжүүлж, үзэгчдэд хүртээл болгох ажлыг зохион байгуулна.
- 1.6.9 Бүжгийн клубүүдийн үйл ажиллагааг дэмжиж, хөгжим, хувцас хэрэгслээр хангана.

- 1.6.10 Соёлын салбарын ажилтнуудын нийгмийн баталгааг хангах чиглэлээр салбарын байгууллагатай хамтран ажиллана.
- 1.6.11 "Жавхлант монгол" ардын урлагийн тоглолтыг бэлтгэж гадаад, дотоодын жуулчдад тоглож орлого олох боломжийг бүрдүүлнэ.
- 1.6.12 Сумын номын сангийн фонд баяжилтыг нэмэгдүүлж, албан хаагчдыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.
- 1.6.13 Соёлын төвийн үзэгчдийн сандал шинэчлэх, LED дэлгэц, FM радиотой болох асуудлыг шийдвэрлэнэ.
- 1.6.14 Гадаадын хөрөнгө оруулагчдын дэмжлэгээр хүүхэд, залуучуудад цанын спортоор хичээллүүлж, мэргэжлийн тамирчин бэлтгэхэд анхаарч ажиллана.
- 1.6.15 Спортын олон улсын хэмжээний томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулах, оролцох асуудлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.6.16 Эрүүл, идэвхтэй аж төрөх талаар сургалт, сурталчилгааг сайжруулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.6.17 Спорт клубүүдийг амжилтаар нь дэмжих бодлого баримтална.
- 1.6.18 Бясалгал, хийн дасгал, нийтийн бүжиг, иог зэрэг чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 1.6.19 Спорт явган аяллыг сумандаа хөгжүүлнэ.

## **ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ**

### **2.1 Жижиг дунд бизнес, бизнесийн дархлаа**

- 2.1.1 Жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, гарцыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийн сан үүсгэж, гарааны бизнесийг бодлогоор дэмжин бүтээгдэхүүн үйлчилгээг мэдээллийн санд байршуулна.
- 2.1.2 Эдийн засгийн түншлэл, Ерөө бүсийн худалдааны салбарыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын худалдааны түншүүдтэй хамтран ажиллана.
- 2.1.3 Гадаад, дотоодын хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, хамтран ажиллана.
- 2.1.4 Сумын ахуйн үйлчилгээний төвийг байнгын тогтмол үйл ажиллагаатай болгоно.
- 2.1.5 Арьс, шир элдэж боловсруулах автомат төхөөрөмжөөр өрхийн үйлдвэрлэлийг дэмжинэ.

### **2.2 Төсөв, санхүү, татварын бодлого**

- 2.2.1 Орон нутгийн үйлдвэрлэгчдийнхээ бүтээгдэхүүнийг худалдан авах хандлагыг нэмэгдүүлж мөнгөн гүйлгээг нутагтаа авч үлдэх бодлого баримтална.
- 2.2.2 Хуриятлалыг бий болгох сургалт мэдээллийн бодлогыг хэрэгжүүлж иргэдийн эдийн засгийн боловсролыг дээшлүүлнэ.
- 2.2.3 Татварын байцаагч, иргэд, аж ахуй нэгж байгууллагын харилцан уялдаа холбоог сайжруулан, татварын зөвлөгөө өгдөг, хуулийг дээдэлдэг, бизнесийг дэмждэг чиглэлийг баримтална.

## **2.3 Дэд бүтэц , барилга**

- 2.3.1 Сумын хөгжлийн болон газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, мөрдөнө.
- 2.3.2 Хувийн хэвшлийн эхлүүлсэн нэгдсэн халаалтын зуух, цэвэр усны шугамын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах санхүүжилтийг холбогдох шатны төсөвт тусгуулан, хэрэгжүүлнэ.
- 2.3.3 Халуун усны барилгын халуун, хүйтэн усны шугамын асуудлыг шийдвэрлэж, жилийн дөрвөн улиралд тогтвортой ажиллагаатай болгоно.
- 2.3.4 Сумын ЗДТГ-ын барилгын болон нийтийн эзэмшлийн гудамж талбай, барилга байгууламжийг засварлах санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулан, хэрэгжүүлнэ.
- 2.3.5 Ерөө голын суурьшлын бүсэд цахилгааны шугам татах ажлыг эхлүүлж, байнгын эх үүсвэрээр хангах санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулан хэрэгжүүлнэ.
- 2.3.6 Шарын голын хорооллоос төв замын уулзвар хүртэл цахилгааны шугам татаж, шатахуун түгээх станц байгуулах асуудлыг бодлогоор дэмжинэ.
- 2.3.7 Бумбат ба Моностой багийн хүүхдийн тоглоомын талбайг шинэчилнэ.
- 2.3.8 Шарын голын гурвалжинд мал угаалгын бanni, жижиг оврын гүүр байгуулж ашиглалтад оруулна.
- 2.3.9 Сумын төвийн малын худгийг сумын төвөөс зүүн тийш шилжүүлэн нүүлгэнэ.
- 2.3.10 Сумын төвийн өнгө үзэмж нэмэх зорилгоор байгууллагуудын гадна туузан гэрэл байршуулж, гудамж зам талбайн гэрэлтүүлгийг нэмж, хуучирч муудсан барилгуудыг сэргээн засварлаж тодорхой нөхцөл гэрээний дагуу иргэдэд ашиглуулна.
- 2.3.11 Багийн иргэдийн нийтийн хурал болон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэр гаргуулж айл өрхүүдийн хашааг нэгэн жигд өнгөөр будаж, жигдриүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.3.12 Сумын төвийн сайжруулсан хайрган хүчилттай замыг бетон зам болгох санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулан хэрэгжүүлнэ.

## **2.4 Аялал жуулчлал**

- 2.4.1 Спортын, эрүүл мэндийн, эко-туризм, ургамал , амьтан судлал , түүх соёлын дурсгалт газруудын судалгаа шинжилгээ экстрим /адал явдалт/ аялал зэрэг аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг дэмжинэ.
- 2.4.2 “Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, жуулчны баазуудын үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
- 2.4.3 Орон нутгийн иргэдийн амьдралд сайнаар нөлөөлөх жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хийх гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж, хамтран ажиллана.
- 2.4.3 Аялал жуулчлалын салбарт ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлнэ.

- 2.4.4 Жавхлант суманд жуулчилж, аялах эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор аялал жуулчлалын баазуудыг түшиглэн ЭВЕНТ арга хэмжээ зохион байгуулна.

#### **2.5 Шинжлэх ухаан технологи, мэдээлэл, харилцаа**

- 2.5.1 Сумын төвд өндөр хурдны интернэтийн сүлжээг өргөтгөж, 5G технологийг нэвтрүүлэх боломжийг судалж, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 2.5.2 Айл өрхийн хаягжилтыг сайжруулан шуудан хүргэлтийн системийг боловсронгуй болгох бодлого баримтална.
- 2.5.3 Багш нарын цахим боловсролын ур чадварыг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

### **ГУРАВ. ОРОН НУТГИЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ**

#### **3.1 Бэлчээр ашиглалт**

- 3.1.1 Бэлчээр ашиглалтыг сайжруулж, сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.
- 3.1.2 Малчдын хамтын оролцоонд тулгуурлан сумын газар нутгийн 40 орчим хувийг эзэлж байгаа бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээнэ.
- 3.1.3 Малчдыг бүлэг, хэсгийн зохион байгуулалтыг сэргээж, бэлчээрийг гэрээгээр ашиглуулах хэлбэрээр бэлчээрт малын даацыг тохируулан бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлнэ.
- 3.1.4 Ашиглалт багатай, олон жил ашигласнаас хөрсний үржил шим муудсан болон олон жилийн судалгаагаар ургац муу өгдөг тариалангийн талбай болон бусад нөөц газраас олон наст уургийн агууламж өндөртэй тэжээлийн ургамал тариалах зориулалтаар малчдад эзэмшүүлнэ.
- 3.1.5 Малыг тооноос чанарт шилжүүлэх, бэлчээрийн даацыг тохируулж, хамгаалж, сайжруулсан малчин өрх, бүлэг, хэсгийг бодлогоор дэмжинэ.
- 3.1.6 Эрчимжсэн мал аж ахуйг бодлогоор дэмжинэ.

#### **3.2 Газар тариалан**

- 3.2.1 Атрын 4-р аяныг хэрэгжүүлнэ.
- 3.2.2 Газар тариалангийн усжуулалтыг боловсронгуй болгож, гадаргуугийн усалгаа, бага оврын услалтын системийг хөгжүүлнэ.
- 3.2.3 Экспортод чиглэсэн өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлнэ.
- 3.2.4 Малын тэжээлийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.
- 3.2.5 Ургамал хамгаалалтын орчин үеийн арга технологийг хэрэгжүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, хортон шавжаас хамгаалах, үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 3.2.6 Дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 3.2.7 Жимс, жимсгэнийн дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжинэ.

- 3.2.8 Тариалангийн талбайн хөрсний агрохимиин шинжилгээг хийлгэх, хөрсний үржил шимийг хамгаалах, ойн зурvas байгуулна.
- 3.2.9 Тариалангийн талбайг хашаажуулах ажлыг тасралтгүй нэмэгдүүлнэ.
- 3.2.10 Хүнсний ногооны зоорь болон борлуулалтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 3.2.11 Бэлчээр, тариалангийн талбайн үлийн цагаан оготно устгалын ажлыг зохион байгуулна.

### 3.3. Мал аж ахуй

- 3.3.1 Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг хөгжүүлэхэд онцгой анхаарч ажиллана.
- 3.3.2 Сумын хэмжээнд малын үүлдэр омог, угшлыг баталгаажуулж төрөлжсөн хэлбэрээр өсгөж үржүүлэх бодлого баримтална.
- 3.3.3 Мал аж ахуйн эрүүл бүсийг баталгаажуулж, мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг чанартай болгож, хяналтыг сайжруулах бодлого баримтална.
- 3.3.4 Махыг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулж, малын вакцин, туулгад бүрэн хамруулж, эрүүлжүүлэх бодлого баримтална.
- 3.3.5 Сум хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэлд малын үүлдэрлэг байдлыг сайжруулах зорилгоор малчдад хээлтүүлэгч авах зээл тусlamж үзүүлэх заалт оруулна.
- 3.3.6 Сумын өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зорилгоор хадлангийн талбайтай болж гамшгийн сан бүрдүүлэх боломжийг хангана.

## ДӨРӨВ. ХАРИУЦЛАГАТАЙ ЖАВХЛАНТ

- 4.1 Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалж, хөгжлийг дэмжин, авилгаас ангид ажиллах чадавхтай засаг, хүн бүр ажил, албан тушаалаасаа үл хамаарч хуулийн өмнө хариуцлага хүлээдэг шударга тогтолцоо, мэргэжлийн, хүртээмжтэй, цахимжсан нийтийн албыг бэхжүүлэхийг дэмжинэ.
  - 4.1.1 Төрийн албан хаагчдын ёс зүй, зан харилцаанд олон нийтийн зүгээс тавих хяналтыг бий болгоно.
  - 4.1.2 Хууль сахиулах байгууллагын үндсэн чиг үүргийг нь иргэдэд аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулалтыг нь иргэний болгох чиглэлийг дэмжиж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд залуусыг гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах арга ажиллагааны хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарна.
  - 4.1.3 Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисоос хамааралтай, донтогч болсон иргэнд эмнэлгийн, сэтгэл зүйн болон нийгмийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх бодлого баримтална.
  - 4.1.4 Гамшиг, аюулаас хамгаалахад нутгийн иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлнэ.
  - 4.1.5 Сумын нутгийн удирдлагын байгууллагын ил тод, нээлттэй байдал, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор цахим ИТХ-ыг жилд 1-ээс доошгүй удаа хийнэ.

- 4.1.6 Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэх ажлыг зохион байгуулна.
- 4.1.7 Төрийн байгууллага, удирдах албан тушаалтан жил бүр иргэдэд ажлын тайлангийн сонсгал хийх ажлыг үргэлжлүүлнэ.
- 4.1.8 Иргэддээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлэх зарчимд тулгуурласан нутгийн удирдлагыг бэхжүүлэх бодлого баримтална.
- 4.1.9 Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуулиудад туссан иргэний оролцоотой хяналт хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 4.1.10 Иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ. цахим өргөдөл, гомдлын үйл ажиллагааг журам боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.1.11 Суманд зохион байгуулах аливаа төсөл, хөтөлбөр тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтийн оролцоотой, ил тод, нээлттэй болгох бодлого баримтална.

#### **ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН ЖАВХЛАНТЧУУД**

- 5.1.1 Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг орон нутагт хэрэгжүүлж, байгууллагуудын хэвийн тогтвортой үйл ажиллагааг хангах бодлого баримтална.
- 5.1.2 БНСУ болон бусад орнуудтай найрсаг хамтын үйл ажиллагаа, гадаад харилцааг өргөжүүлэх бодлого баримтална.
- 5.1.3 Соёлын биет болон биет бус өвийг сумын баялагт тооцож, холбогдох байгууллагуудад бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, үрэгдэж гэмтэх, гадагш алдагдахаас хамгаална.
- 5.1.4 Төрийн албан хаагчдын ар гэрийн аюулгүй байдал, нийгмийн асуудлыг холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлэнэ.
- 5.1.5 Иргэн бүрийн аюулгүй байдлаа хангахад хэрэгтэй мэдлэг мэдээллийг нийтэд түгээж, иргэдийн оролцоог дэмжинэ.

#### **ЗУРГАА. ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ**

- 6.1.1 Усны хэрэглээ, хяналт, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлж, ухаалаг худгийг тогтвортой ажиллуулж, ус зөөлрүүлэгчийг саадгүй ажиллуулж ард иргэдийг цэвэр усаар хангана.
- 6.1.2 Бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлж, цэлжилттэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 6.1.3 Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, шинэ технологи нэвтрүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 6.1.4 Ой, рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 6.1.5 Байгаль хамгаалах тухай хууль, журмыг зөрчсөн аж ахуйн нэгж иргэдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

- 6.1.6 Байгаль орчинд ээлтэй “Ногоон Жавхлант” хөтөлбөрийн хүрээнд “Өрх бүр цэцэрлэгч” хөдөлгөөнийг өрнүүлж ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 6.1.7 Төвлөрсөн хогийн цэгийг цэвэрлэх, цэгцлэх ажлыг хийж, байнгын хяналттай болгоно.
- 6.1.8 Иргэдийн хэрэглээний болон түлээний модны хэрэгцээг ойн сан бүхий сумдтай гэрээ хийж шийдвэрлэнэ.
- 6.1.9 Гэр хорооллын иргэдэд үйлчлэх түлээ, нүүрс худалдах аж ахуй нэгж, иргэдийг бодлогоор дэмжинэ.
- 6.1.10 Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, ойн талаар баримтлах бодлогыг хүрээнд улс, аймаг, орон нутгийн санхүүжилтээр жил бүр 0,5-аас доошгүй га талбайд ойжуулалт хийнэ.

